



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2023 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 1/451

Улаанбаатар хот

Сувилагч, Эх баригч мэргэжилтний  
цогц чадамжийг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.8, 8.1.20 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.12 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сувилагч мэргэжилтний цогц чадамжийг нэгдүгээр, Эх баригч мэргэжилтний цогц чадамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сувилагч, Эх баригч мэргэжилтний албан тушаалын жишиг тодорхойлолтыг цогц чадамжтай уялдуулан боловсруулж 2024 оны хоёрдугаар улиралд багтаан батлуулахыг Бодлого төлөвлөлтийн газар (П.Оюунцэцэг)-т үүрэг болгосугай.

3. Сувилахуйн болон эх барихуйн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон тасралтгүй сургалтын хөтөлбөрийг цогц чадамжид нийцүүлэн боловсруулж, батлуулан мөрдөн ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа), төгсөлтийн дараах сургалт эрхлэх байгууллагын дарга/ захирал нарт даалгасугай.

4. Шинэ сувилагч, шинэ эх баригчийн сургалтын хөтөлбөрийг 2024 оны дөрөвдүгээр улиралд багтаан батлан, мөрдүүлэхийг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа)-д үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн дарга С.Төгсдэлгэрт даалгасугай.



141224927

Эрүүл мэндийн сайдын 2023  
12 сарын 20 өдрийн 11 дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт

## Сувилагч мэргэжилтний цогц чадамж

### Нэг. Үндэслэл

Монгол Улсын Эрүүл мэндийн яам болон Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА) хамтран “Эмч болон сувилагчийн төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл”-ийг 2021-2024 онд хэрэгжүүлж байна. Энэхүү төслийн нэг зорилт нь сувилахуйн цогц чадамжийг боловсруулж, шинэ сувилагчийг ажлын байран дээр нь сургаж дадлагажуулах, төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрийг шинээр болон шинэчлэн боловсруулах, нэвтрүүлэх замаар төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах юм.

Сувилагч мэргэжилтний цогц чадамж нь тэдний албан тушаалын тодорхойлолт боловсруулах, шинээр ажилд ороход ажлын байран дээр нь сургаж чадавхжуулах гарын авлага боловсруулах, сувилагч мэргэжилтнийг хөгжүүлэх эмнэл зүйн ур чадварын шатлалыг тодорхойлох, сувилахуйн чадамжид суурилсан төгсөлтийн дараах тасралтгүй болон мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх суурь баримт бичиг болно.

### Хоёр. Зорилго

Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд нийцсэн сувилахуйн тусlamж, үйлчилгээ үзүүлэх цогц чадамж бүхий сувилагч мэргэжилтэн бэлтгэнэ.

### Гурав. Алсын хараа

Монгол Улсын хэмжээнд сувилахуйн тусlamж, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай мэргэжлийн үнэ цэнэ, мэдлэг, ур чадварыг эзэмшсэн, мэргэжлийн ёс зүй, үүрэг хариуцлагаа бүрэн ойлгосон, бие дааж болон багаар ажиллаж сувилахуйн тусlamж, үйлчилгээг үр дүнтэй үзүүлдэг мэргэшсэн сувилагчтай болно.

### Дөрөв. Сувилагч мэргэжилтний цогц чадамж, бүрэлдэхүүн хүчин зүйл

Сувилагч мэргэжилтний цогц чадамжийн бэлгэдэл: Урт удаан наслахыг бэлгэддэг “өлзий хээ”-ээр чимэглэсэн улбар шар өнгө бүхий “Монгол гэрийн тооно”-оор сувилахуйн цогц чадамжийн бэлгэдлийг дүрсэлж, тоононы цонх хэсэгт сувилагч мэргэжилтний 5 цогц чадамжийг оруулан дүрсэлсэн.



Сувилагч мэргэжилтний цогц чадамж гэдэг нь сувилахуйн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах мэргэжлийн үнэ цэнэ, мэдлэг, ур чадвар, харилцаа, хандлага бүхий хувь хүн болон багаар ажиллахад хамгийн үр дүнтэй байх ур чадварын цогц ойлголт юм. Сувилагч мэргэжилтний эзэмшсэн байх цогц чадамжид дараах 5 чадвар багтана. Үүнд:

#### 4.1. Мэргэжлийн үүрэг хариуцлагаа биелүүлэх чадвар

Тодорхойлолт: Сувилагч мэргэжилтний хувьд хариуцлагатай байж, ёс зүйг эрхэмлэн, хууль эрх зүйн хүрээнд сувилахуйн тусламж, үйлчилгээг үзүүлэх чадвар юм.

Бүрэлдэхүүн хүчин зүйл:

- Хариуцлага хүлээх чадвар- өөрийн үзүүлж буй сувилахуйн тусламж, үйлчилгээний үр дүн болон гаргасан шийдвэртээ хариуцлага хүлээнэ.
- Тусламж, үйлчилгээг мэргэжлийн ёс зүйтэй үзүүлэх чадвар- ёс зүйг баримтлан сувилахуйн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.
- Хууль эрх зүйн баримт бичгийг мөрдөж ажиллах чадвар- сувилахуйн тусламж, үйлчилгээтэй холбоотой хууль, стандарт, зааврын дагуу тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

#### 4.2. Сувилахуйн тусламж, үйлчилгээ үзүүлэх чадвар

Тодорхойлолт: Үйлчлүүлэгч бүрт тохирсон сувилахуйн тусламж, үйлчилгээг сувилгааны үйл ажиллагаанд үндэслэн хэрэгжүүлэх чадвар юм.

Бүрэлдэхүүн хүчин зүйл:

- Хэрэгцээ тодорхойлох чадвар- тусламж, үйлчилгээний хэрэгцээг тодорхойлж, сувилахуйн чухал асуудлыг нь эрэмбэлнэ.
- Асран сувилах чадвар- сувилахуйн үйл ажиллагааны таван шатлалын дагуу сувилахуйн төлөвлөгөөг гаргаж, үйлчлүүлэгчийн биеийн байдалтай уялдуулан итгэлтэй харилцааг тогтоон тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

- Шийдвэрийг дэмжих чадвар- үйлчлүүлэгчийн соёл, үнэт зүйлд үндэслэн үйлчлүүлэгч өөрөө шийдвэр гаргахыг нь дэмжинэ.

#### 4.3. Багаар ажиллах чадвар

Тодорхойлолт: Ижил мэргэжилтэн болон бусад мэргэжлийн хүмүүстэй хамтран ажиллаж, сувилахуйн тусlamж, үйлчилгээний чиглэлийг харилцан хэлэлцэж, ажил үүргийн хуваарилалт хийн тусlamж, үйлчилгээг хамтдаа үзүүлэх чадвар юм.

Бүрэлдэхүүн хүчин зүйл:

- Харилцааны чадвар- байгууллагын алсын хараа, эрхэм зорилгыг ойлгож, ижил мэргэжилтэн, бусад мэргэжлийн хүмүүстэй харилцаж, шаардлагатай мэдээлэл, санал солилцож ажиллана.
- Хамтран ажиллах чадвар- ижил мэргэжилтэн болон бусад мэргэжлийн хүмүүстэй хамтран ажиллаж, нөхцөл байдалд тохируулан ажил үүргийн дахин хуваарилалт хийж, баг дотроо харилцан бие биеэ дэмжин ажиллана.

#### 4.4. Менежмент, манлайллын чадвар

Тодорхойлолт: Сувилагч мэргэжилтний хувьд сувилахуйн тусlamж, үйлчилгээг багаар үр дүнтэй, бүтээмжтэй үзүүлэхэд багийн гишүүний хувиар нөхцөл байдалд нийцуулэн манлайлан оролцож, менежмент хийх чадвар юм.

Бүрэлдэхүүн хүчин зүйл:

- Зохион байгуулах, хяналт тавих чадвар- сувилахуйн тусlamж, үйлчилгээг үзүүлэх орчин нөхцөл, хүний нөөцийг зохицуулна.
- Аюулгүй байдлыг хангах чадвар- сувилахуйн тусlamж, үйлчилгээг үзүүлэхдээ эрсдэл, аюулгүй байдлыг харгалzan үзэж, эрсдэлийн менежментийг хэрэгжүүлнэ.
- Байгууллагын гишүүний үүрэг гүйцэтгэх чадвар- заан сургах, чиглүүлэх арга зүйг ашиглан сувилахуйн тусlamж, үйлчилгээ авч байгаа үйлчлүүлэгч болон багийн үйл ажиллагаанд зохицуулалт хийнэ.

#### 4.5. Сувилахуйн мэргэшсэн байдлаа сайжруулах чадвар

Тодорхойлолт: Сувилахуйн тусlamж, үйлчилгээ үзүүлэх чадвараа хөгжүүлэхийн зэрэгцээ, сувилагч мэргэжилтний үнэ цэнийг үйлчлүүлэгч төдийгүй нийгэмд таниулах чадвар юм.

Бүрэлдэхүүн хүчин зүйл:

- Сувилагч мэргэжлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх чадвар- сувилахуйн тусlamж, үйлчилгээний хэрэгцээг тодорхойлж, шаардлагатай эмнэл зүйн сургалтыг явуулна.
- Нийгэмд хувь нэмэр оруулах чадвар - нийгэмд сувилагч мэргэжилтний үнэ цэнийг таниуулна.

- Сувилахуйн эмнэл зүйн ур чадварыг сайжруулах чадвар - нотолгоонд суурилсан сувилахуйн тусламж, үйлчилгээг сайжруулахад багаар хамтран ажиллана.
- Тасралтгүй суралцах чадвар - өөрийн чадварыг хөгжүүлж тасралтгүй суралцана.

#### Тав. Хүрэх үр дүн

5.1. Цогц чадамжтай сувилагч мэргэжилтнийг бэлтгэхэд хувь хүн болон байгууллага нь хариуцлагатай байж, дэмжлэг үзүүлэн хамтран ажилласнаар сувилахуйн салбарын хөгжилд ахиц дэвшил гарах төдийгүй эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар сайжирч, нийгэмд сувилагч мэргэжилтний нэр хүндийг өсгөх, ур чадварыг хөгжүүлэх, ажлын гүйцэтгэлийг үндэлэх үндэслэл болно.

5.2. Сувилагч мэргэжилтний ур чадвар энэхүү цогц чадамжийн хүрээнд хэрхэн дээшилж, сайжирч байгаад үнэлгээ хийж, дүгнэснээр нотолгоонд суурилсан сайжруулалт хийх суурь болно.

5.3. Сувилагч мэргэжилтний цогц чадамжид тулгуурлан цаашид эмнэл зүйн ур чадварын шатлалыг Монголын Улсын онцлогт тохируулан боловсруулж хэрэгжүүлэх, үндэсний хэмжээнд шинэ сувилагчийг ажлын байранд сургаж, чадавхжуулах хөтөлбөр болон чадамжид суурилсан төгсөлтийн дараах тасралтгүй болон мэргэшүүлэх сургалтын жишиг нэгдсэн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах зэрэгт суурь болно.

5.4. Жишиг нэгдсэн хөтөлбөртэй болсноор ялангуяа сувилахуйн төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтын чанарт ахиц дэвшил гарч улсын хэмжээнд ижил түвшинд сувилахуйн тусламж, үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах мэдлэг, ур чадварыг эзэмшсэн цогц чадамжтай мэргэшсэн сувилагчийг бэлтгэнэ.

12 Эрүүл мэндийн сайдын 2023  
сарын 20-и  
адрийн 151 дугаар  
тушаалын хоёрдугаар хавсралт

### Эх баригч мэргэжилтний цогц чадамж

#### Нэг. Үндэслэл

Монгол Улсын Эрүүл мэндийн яам болон Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА) хамтран “Эмч болон сувилагчийн төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл”-ийг 2021-2024 онд хэрэгжүүлж байна. Энэхүү төслийн нэг зорилт нь эх барихуйн цогц чадамжийг боловсруулж, шинэ эх баригчийг ажлын байран дээр нь сургаж дадлагажуулах, төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрийг шинээр болон шинэчлэн боловсруулах, нэвтрүүлэх замаар төгсөлтийн дараах сургалтын тогтолцоог сайжруулах юм.

Энэхүү цогц чадамж нь эх баригч мэргэжилтний албан тушаалын тодорхойлолт боловсруулах, шинээр ажилд ороход ажлын байран дээр нь сургаж чадавхжуулах гарын авлага боловсруулах, эх баригч мэргэжилтнийг хөгжүүлэх эмнэл зүйн ур чадварын шатлалыг тодорхойлох, эх барихуйн чадамжид суурилсан төгсөлтийн дараах тасралтгүй болон мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх суурь баримт бичиг болно.

#### Хоёр. Зорилго

Охид, эмэгтэйчүүдийн хэрэгцээнд нийцсэн нөхөн үржихүйн эрүүл мэндийн болон эх барихуйн тусламж, үйлчилгээ үзүүлэх цогц чадамж бүхий эх баригч мэргэжилтэн бэлтгэнэ.

#### Гурав. Алсын хараа

Монгол Улсын хэмжээнд эх, ураг, нярайн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах мэдлэг, ур чадварыг эзэмшсэн, мэргэжлийн ёс зүй, үүрэг хариуцлагаа бүрэн ухамсарласан, бие дааж болон багаар ажиллан эх барихуйн тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй үзүүлэх цогц чадамж бүхий мэргэшсэн эх баригчтай болно.

#### Дөрөв. Эх баригч мэргэжилтний цогц чадамж, бүрэлдэхүүн хүчин зүйл

Эх баригч мэргэжилтний цогц чадамжийн бэлгэдэл: Зүүний үзүүрт тогтсон будааны ширхэгийг хүмүүн болж төрөх амьдралын гайхамшигтай зүйрлэж, Монгол Улсын хүн амын өсөхийг бэлгэдэж арвин ихийн бэлэгдэл тариан түрүүн хээтэй, эх баригчийн мэргэжлийг илэрхийлэх ягаан өнгө бүхий “Монгол гэрийн тооно”-оор эх баригчийн цогц чадамжийг илэрхийлсэн. Төв хэсэгт хорвоо ертөнцийн бүхий л юмс хос тэгш оршино гэдгийг илэрхийлэх арга билгийг оруулсан байна.

Эрүүл мэндийн сайдын 2023  
12 сарын 20 өдрийн 1451 дугаар  
тушаалын хоёрдугаар хавсралт

### Эх баригч мэргэжилтний цогц чадамж

#### Нэг. Үндэслэл

Монгол Улсын Эрүүл мэндийн яам болон Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА) хамтран “Эмч болон сувилагчийн төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл”-ийг 2021-2024 онд хэрэгжүүлж байна. Энэхүү төслийн нэг зорилт нь эх барихуйн цогц чадамжийг боловсруулж, шинэ эх баригчийг ажлын байран дээр нь сургаж дадлагажуулах, төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрийг шинээр болон шинэчлэн боловсруулах, нэвтрүүлэх замаар төгсөлтийн дараах сургалтын тогтолцоог сайжруулах юм.

Энэхүү цогц чадамж нь эх баригч мэргэжилтний албан тушаалын тодорхойлолт боловсруулах, шинээр ажилд ороход ажлын байран дээр нь сургаж чадавхжуулах гарын авлага боловсруулах, эх баригч мэргэжилтнийг хөгжүүлэх эмнэл зүйн ур чадварын шатлалыг тодорхойлох, эх барихуйн чадамжид суурилсан төгсөлтийн дараах тасралтгүй болон мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх суурь баримт бичиг болно.

#### Хоёр. Зорилго

Охид, эмэгтэйчүүдийн хэрэгцээнд нийцсэн нөхөн үржихүйн эрүүл мэндийн болон эх барихуйн тусламж, үйлчилгээ үзүүлэх цогц чадамж бүхий эх баригч мэргэжилтэн бэлтгэнэ.

#### Гурав. Алсын хараа

Монгол Улсын хэмжээнд эх, ураг, нярайн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах мэдлэг, ур чадварыг эзэмшсэн, мэргэжлийн ёс зүй, үүрэг хариуцлагаа бүрэн ухамсарласан, бие дааж болон багаар ажиллан эх барихуйн тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй үзүүлэх цогц чадамж бүхий мэргэшсэн эх баригчтай болно.

#### Дөрөв. Эх баригч мэргэжилтний цогц чадамж, бүрэлдэхүүн хүчин зүйл

Эх баригч мэргэжилтний цогц чадамжийн бэлгэдэл: Зүүний үзүүрт тогтсон будааны ширхэгийг хүмүүн болж төрөх амьдралын гайхамшигтай зүйрлэж, Монгол Улсын хүн амын өсөхийг бэлгэдэж арвин ихийн бэлэгдэл тариан түрүүн хээтэй, эх баригчийн мэргэжлийг илэрхийлэх ягаан өнгө бүхий “Монгол гэрийн тооно”-оор эх

баригчийн цогц чадамжийг илэрхийлсэн. Төв хэсэгт хорвоо ертөнцийн бүхий л юмс хос тэгш оршино гэдгийг илэрхийлэх арга билгийг оруулсан байна.



Эх баригчийн цогц чадамж гэдэг нь эх, нярай, эмэгтэйчүүд, тэдгээрийн гэр бүлд нөхөн үржихүйн болон эх барихуйн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах мэргэжлийн үнэ цэнэ, мэдлэг, ур чадвар, харилцаа хандлагын цогц ойлголт юм. Эх баригч мэргэжилтний эзэмшсэн байх цогц чадамжид дараах 6 чадвар багтана. Үүнд:

#### 4.1. Жирэмслэхээс өмнөх нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чадвар

Тодорхойлолт: Эх баригч нь эмэгтэйчүүд, өсвөр үе, тэдний гэр бүлийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, эрсдэлийг эрт илрүүлэхэд чиглэсэн, үйлчлүүлэгчийг бие даан шийдвэр гаргах, хувийн хяналттай байхад нөлөөлж чадахуйц тусламж, үйлчилгээ үзүүлэх чадвар юм.

Бүрэлдэхүүн хүчин зүйл:

- Жирэмслэхээс өмнөх эмэгтэйчүүд, өсвөр үе, тэдний гэр бүл эрүүл байхыг дэмжих чадвар;
- Сэтгэл ханамж бүхий аюулгүй бэлгийн амьдралыг дэмжих чадвар;
- Бэлгийн эрүүл мэнд ба эрхтэй холбоотой бие даан шийдвэр гаргалтыг дэмжих чадвар;
- Хувь хүний онцлогт тохирсон гэр бүл төлөвлөлтийн аргыг сонгон хэрэглэхэд нь чиглэсэн мэдээлэл болон зөвлөгөө өгөх чадвар;
- Бэлгийн замаар дамжих халдварт (БЗДХ)-аас сэргийлэх мэдээлэл болон зөвлөгөө өгөх чадвар;
- Өсвөр насны онцлог болон хүсэл сонирхлыг хүндэлж, бэлгийн талаарх мэдээлэл болон зөвлөгөө өгөх чадвар;
- Төлөвлөөгүй эсвэл хүсээгүй жирэмсэлсэн эмэгтэйчүүдэд тусламж, үйлчилгээ үзүүлэх чадвар.

#### 4.2 Жирэмсэн үеийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх чадвар

Тодорхойлолт: Эх баригч нь жирэмсэн эмэгтэйчүүд, ургийн байдлыг үнэлж, эрүүл мэндийг сахин хамгаалах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Бүрэлдэхүүн хүчин зүйлс:

- Жирэмснийг эрт илрүүлж, жирэмсний хяналтыг хийж, жирэмсэн эмэгтэй, ургийн байдлыг үнэлж, жирэмсний эрсдэл, хүндрэл, эмгэгийг илрүүлж, цаг алдалгүй хариу арга хэмжээ авах чадвар;
- Жирэмсэн эмэгтэйн сэтгэл зүйн онцлогт тохирсон эрүүл мэндийн боловсрол олгох (хооллолт, дасгал хөдөлгөөн, эхийн сүүгээр хооллох гэх мэт) чадвар;
- Эцэг, эх болоход бэлтгэх зөвлөгөө өгөх ба сургалт явуулах чадвар.

#### 4.3 Төрөх үеийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх чадвар

Тодорхойлолт: Эх баригч нь төрөх үеийн эх, ургийн байдлыг үнэлж, аюулгүй, үр дүнтэй, хүндэтгэлтэй эх барихын тусlamж, үйлчилгээ үзүүлнэ.

Бүрэлдэхүүн хүчин зүйлс:

- Төрөлтийн явцыг үнэлж, төрөлтийг аюулгүй явуулах нотолгоонд суурилсан тусlamж, үйлчилгээг үзүүлэх чадвар;
- Эх амар амгалан, аюулгүй байдааар төрөх үеийг даван туулахад нь бие болон сэтгэлзүйн байдалд нь тохирсон тусlamж, үйлчилгээ үзүүлэх чадвар;
- Эмгэг өөрчлөлтийг эрт илрүүлж, эмчид мэдээлэх, багийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх чадвар;
- Дөнгөж төрсөн нярайд тусlamж, үйлчилгээ үзүүлэх чадвар.

#### 4.4 Төрсний дараах эх, нярайн тусlamж, үйлчилгээ үзүүлэх чадвар

Тодорхойлолт: Эх баригч нь төрсөн эх, нярайн эрүүл мэндийг сахин хамгаалах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, хэвийн бус байдал, хүндрэлийг эрт илрүүлэхэд чиглэсэн тусlamж, үйлчилгээ үзүүлнэ.

Бүрэлдэхүүн хүчин зүйлс:

- Төрсөн эх, нярайн хүндрэлийг эрт илрүүлж, хянах чадвар;
- Нярайн асаргаа, эхийн сүүгээр хооллохыг дэмжих, хөхний эмгэгийн (хөхний мастит, хорт хавдар г.м.) үед хариу арга хэмжээ авах чадвар;
- Төрсөн эхэд гэр бүл төлөвлөлтийн талаар мэдээлэл зөвлөгөө өгч, тусlamж үйлчилгээ үзүүлэх чадвар;
- Төрсний дараах үеийн сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг үнэлж, сэтгэцийн хямралыг илрүүлэх, хариу арга хэмжээ авах чадвар;
- Эх, үрийн нандин холбоог бэхжүүлэх, эхийн хайраар хүүхдээ өсгөхөд нь дэмжлэг үзүүлэх чадвар;
- Гэрийн эргэлт хийж, эх хүүхдийг үнэлж, зохистой тусlamж, үйлчилгээ үзүүлж, эмнэлгийн бусад мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах чадвар.

#### 4.5 Бие даасан мэргэжилтэн байх чадвар

Тодорхойлолт: Эх баригч нь мэргэжлийн өндөр ёс зүйтэй, өөртөө итгэлтэй, тасралтгүй суралцагч, эмэгтэйчүүд, охид, тэдний гэр бүлтэй сайн харилцаа тогтоож, бусад эмнэлгийн мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах чадвартай мэргэжилтэн байна.

Бүрэлдэхүүн хүчин зүйл:

- Мэргэжлийн ёс зүй, хүний эрхийг хамгаалахтай холбоотой хууль, журмыг мөрдөн ажиллах чадвар;
- Бусад мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж, багийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх чадвар;
- Мэргэжлийн нийгэмлэг холбоодын гишүүн байж, нийгэмд чиглэсэн үйл ажиллагаанд манлайлан оролцох чадвар;
- Мэдлэг, чадвараа тасралтгүй дээшлүүлж, тусlamж, үйлчилгээний чанарыг сайжруулах чадвар;
- Судалгаа хийж, нотолгоонд сууринсан тусlamж, үйлчилгээ үзүүлэх чадвар.

#### 4.6. Харилцагчийн чадвар

Тодорхойлолт: Эх баригч нь эмэгтэйчүүд, өсвөр үе, тэдний гэр бүлийн гишүүн бүртэй хүнлэг энэрэнгүй, хүндэтгэлтэй, зөв харилцаж аюулгүй, хүртээмжтэй, чанартай тусlamж, үйлчилгээ үзүүлнэ.

Бүрэлдэхүүн хүчин зүйл:

- Хүний эрхийг хүндэлж, хэрэгцээнд нь нийцсэн тусlamж, үйлчилгээг үзүүлэх чадвар;
- Шийдвэр гаргалтыг дэмжих чадвар;
- Эелдэг, халамжтай байж эмэгтэйчүүд, хүүхдүүдийн мэдрэмжийг ойлгон сонсож, хамт байх чадвар;
- Хүчирхийлэл (бие махбодь, сэтгэл санаа, эдийн засаг, бэлгийн хүчирхийлэл)-д өртсөн эмэгтэйчүүд болон тусгай хэрэгцээтэй (мансууруулах бодис хэрэглэдэг, хөгжлийн бэрхшээлтэй гэх мэт) эмэгтэйчүүд, хүүхдүүдэд хариу арга хэмжээ авах чадвар;
- Өсвөр насыхны тулгамдаж буй асуудал болон өсвөр насын жирэмслэлтийн үед хариу арга хэмжээ авах чадвар;
- Эмнэлгийн бусад мэргэжилтнүүдтэй харилцах, хамтран ажиллах, эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ үзүүлэх чадвар.

### Тав. Хүрэх үр дүн

5.1. Эх баригч мэргэжилтний цогц чадамжийг тодорхойлсноор нийгэмд тэдний нэр хүндийг өсгөх, эх барихын салбарын хөгжилд ахиц дэвшил гарч нөхөн үржихүйн тусlamж, үйлчилгээний чанар сайжрахаас гадна эх баригчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх үндэслэл болно.

5.2. Цогц чадамж гарснаар эх баригч мэргэжилтний ур чадвар хэрхэн сайжирч, хөгжиж байгаад үнэлгээ, дүгнэлт хийх, тухайн үеийн нийгэм, эрүүл мэндийн салбарын нөхцөл байдалтай уялдуулан сайжруулах боломжтой болно.

5.3. Эх баригч мэргэжилтний цогц чадамжид тулгуурлан эмнэл зүйн ур чадварын шатлалыг өөрийн орны онцлогт тохируулан боловсруулах, хэрэгжүүлэх, үндэсний хэмжээнд шинэ эх баригчийг эмнэл зүйн ур чадварт сургаж, чадавхжуулах, гарын авлага, удирдамжийг боловсруулах, чадамжид суурилсан төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтын жишиг нэгдсэн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах суурь болно.